

САЙН ДУРЫН ДААТГАЛ

НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР ДАРААХ ИРГЭН ДААТГУУЛНА

- ✓ Оюутан
- ✓ Малчин
- ✓ Хувиараа хөдөлмөр эрхлэгч
- ✓ Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд
- ✓ Лангуу түрээслэгч
- ✓ Газар, тариалан эрхлэгч
- ✓ Бичил уурхай эрхлэгч
- ✓ Чөлөөт уран бүтээлч

Хэрвээ Та сайн дураар даатгуулахаар шийдсэн бол нийгмийн даатгалын дараах 3 төрөлд даатгуулна. Үүнд:



ИРГЭН ТА

- Тэтгэврийн даатгал
- Тэтгэмжийн даатгал
- ҮОМШӨ-ний даатгал



Шимтгэл тооцох орлогын доод хэмжээ нь тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, дээд хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧ ИРГЭН ТА

Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	Хувь хэмжээ	Улсын төсвөөс төлөх дүн	Даатгуулагчийн төлөх дүн
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 660.000₮ төгрөгөөс тооцож төлөх бол	13.5%	-	89100₮
Өөрөө мэдүүлэх орлогын дээд хязгаар 4.620.000₮	13.5%	-	Орлогын дээд хязгаараас төлөх дүн 623700₮

МАЛЧИН ДААТГУУЛАГЧИЙН САЙН ДУРЫН ДААТГАЛ

Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	Хувь хэмжээ	Улсын төсвөөс төлөх дүн	Даатгуулагчийн төлөх дүн
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 660.000₮ төгрөгөөс тооцож төлөх бол	13.5%	41250₮	47850₮
Өөрөө мэдүүлсэн орлогоос төлөх бол	13.5%	41250₮	Нийт төлөх дүнгээс 41250₮ хассан дүнгээр

**ХҮҮХДЭЭ 3 НАС
ХҮРТЭЛ НЬ
АСАРЧ БАЙГАА ЭХИЙН
САЙН ДУРЫН ДААТГАЛ**

Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	Хувь хэмжээ	Улсын төсвөөс төлөх дүн	Даатгуулагчийн төлөх дүн
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 660.000₮ төгрөгөөс тооцож төлөх бол	13.5%	37950₮	51150₮
Өөрөө мэдүүлсэн орлогоос төлөх бол	13.5%	37950₮	Нийт төлөх дүнгээс 37950₮ хассан дүнгээр

**ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ 18
ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДЭЭ
ХАРЖ БАЙГАА АЖИЛ
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЭГҮЙ
ЭХ /ЭЦЭГ/-ИЙН
САЙН ДУРЫН ДААТГАЛ**

Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	Хувь хэмжээ	Улсын төсвөөс төлөх дүн	Даатгуулагчийн төлөх дүн
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 660.000₮ төгрөгөөс тооцож төлөх бол	13.5%	75900₮	13200₮
Өөрөө мэдүүлсэн орлогоос төлөх бол	13.5%	75900₮	Нийт төлөх дүнгээс 75900₮ хассан дүнгээр

НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР ДААТГУУЛСАН НӨХЦӨЛД ДАРААХ ТӨРЛИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАХ ЭРХТЭЙ

Та тэтгэврийн даатгалд даатгуулснаар

- Өндөр насны тэтгэвэр (10-аас дээш жил шимтгэл төлсөн байх)
- Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр (3-аас дээш жил шимтгэл төлсөн байх)
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр (5-аас дээш жил)

Тэтгэмжийн даатгалд даатгуулснаар

- Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж (3-аас дээш сар шимтгэл төлсөн байх)
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж (нийтдээ 12 сар, сүүлийн 6 сар тасралтгүй шимтгэл төлсөн байх)
- Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж (36 сараас дээш шимтгэл төлсөн байх)

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулснаар шимтгэл төлсөн хугацаа харгалзахгүйгээр

- Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж
- Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр авах эрхтэй

Даатгал таны ирээдүйн баталгаа